



**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ:
Банкны салбар ба бодлогын зорилтууд**

МОНГОЛБАНК

2022.10.25

Улаанбаатар хот

- Монголбанк дангаараа хэрэгжүүлэх зорилтууд
 - ❖ Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд
 - ❖ Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд

Цар тахал, геополитикийн асуудлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулж, тогтвортой байдлыг хамгаалахад мөнгө, санхүүгийн болон макро зохистой бодлогын арга хэмжээг чиглүүлнэ.

Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

- 2.1. Банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгсэл, үнэлгээний аргачлалыг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх бодлого, арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- 2.2. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд банкны салбарын макро стресс тестийн аргачлалыг боловсронгуй болгож, системийн болон тухайлсан банкны эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлнэ.
- 2.3. Банкны салбарын зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийн үр дүнтэй байдлыг сайжруулах, харилцагчийн хууль ёсны эрх хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ.

ТМБҮЧ 2023: 2.1 заалтын үндэслэл

- Хяналт шалгалтын аргачлалыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх хүрээнд зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх.
 - Банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын дотоод үнэлгээ, удирдлагыг оновчтой хийх, гүйцэтгэх чадварыг бэхжүүлэх зорилгоор Базелын цуврал стандартад тусгагдсан аргачлалуудыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан нэвтрүүлэх. (Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал)
- Банкны салбарын эрсдэл даах чадварыг бэхжүүлэх зорилгоор банкны хяналт шалгалтын хүрээнд тогтоосон олон улсын стандарт, банкны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.
 - Хувьцаат компанийн хэлбэртэй банкны хяналт, зохицуулалтыг санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах замаар хяналт шалгалтын давхардал үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.



ТМБҮЧ 2023: 2.2 заалтын үндэслэл

- Гадаад, дотоод эдийн засгийн сөрөг нөлөөгөөр банкны салбар болон банкуудад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлох, санхүүгийн тогтвортой байдал муудахаас сэргийлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх үүднээс системийн эрсдэлийн шинжилгээний аргачлалуудыг хөгжүүлж хэрэгжүүлэх шаардлагатай.
- Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Базел стандартын Бүлэг 2-ын хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP), банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP), төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ийг шат дараатай мөрдүүлэхэд банкны салбарын Макро стресс тестийн аргачлалыг хөгжүүлэх шаардлагатай.



ТМБҮЧ 2023: 2.3 заалтын үндэслэл

- Зээлийн хүүг бууруулах, чанаргүй зээлийг шийдвэрлэх хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон суурь хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.
 - Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх,
 - Зээл төлүүлэх ажиллагааг шүүхийн бус журмаар шийдвэрлэх,
 - Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үүсч буй тулгамдсан асуудлын талаар олон нийтэд зөв ойлголт бүрдүүлэх, холбогдох судалгааны үр дүнг нийтэд танилцуулах.
 - Зохицуулагч байгууллагаас тавих хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх
 - Маргааныг шүүхийн бус журмаар хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий санхүүгийн омбудсманыг байгуулах



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл (үргэлжлэл)

Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

- 3.1. Дотоод, гадаад төлбөр тооцоог хэвийн үргэлжлэх нөхцлийг бүрдүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, төлбөрийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлнэ.
- 3.2. Иргэд болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.3. Монголбанкны бодлого, үйл ажиллагаанд их өгөгдлийг ашиглах бэлтгэл ажлын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн үе шаттайгаар хөгжүүлнэ.
- 3.4. Монгол Улсын гүйлгээнд хүчин төгөлдөр ашиглаж буй мөнгөн тэмдэгтийн эдийн засгийн үр ашиг бүхий зохистой бүтцийг судалж, танилцуулна.



ТМБҮЧ 2023: 3.1 заалтын үндэслэл

- Үндэсний төлбөрийн системийн бодлого, зохицуулалтыг сайжруулж, шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжинэ.
- Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг зөв удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоо, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.
- Үндэсний төлбөрийн системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгоход тулгарч буй хуулийн давхардал, хийдэл байгаа эсэхийг судлах, шаардлагатай баримт бичгийн төсөл боловсруулна;
- Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нийцүүлж баталсан захиргааны хэм хэжээмний акт, журам, зааварт шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулна;



- Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, СЗХ хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2015 онд баталж 2016-2021 оны хооронд 4-н тэргүүлэх чиглэлээр амжилттай хэрэгжүүллээ.
- Цаашид энэхүү хөтөлбөрийн үргэлжлэл болгон иргэдэд эдийн засгийн мэдлэг олгох дараагийн шатны стратегийг боловсруулах, Иргэдийн эдийн засгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа хийх, эдийн засгийн мэдлэг олгох дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулна
- Иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь санхүүгийн харилцагчийг дунд болон урт хугацаанд санхүүгийн хүндрэлд орох эрсдэлээс хамгаалах болно.

- Бодлогын шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлэх зорилтыг 2022 онд баримтлах үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд:
 - Банкны системийн цахим баримт бичгийг мэдээллийн сүлжээний тусгайлсан нэг шугамаар цуглуулж, хадгалах, боловсруулах, ашиглах зорилготой мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэж байна.
 - Монголбанкны мэдээлэл цуглуулах, хадгалах үйл ажиллагааны дэс дараалал, үйл явцыг өөрчлөх учраас мэдээллийн урсгалын тогтолцоо болон мэдээллийн аюулгүй байдлын менежментийг шинэ системтэй уялдуулан зохион байгуулах нөхцөл шаардлагыг бий болгож байна.
- Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх замын зураглалыг боловсруулж, Цахим хөгжлийн багц хуультай уялдуулан олон улсын стандартыг төв банкны хэмжээнд шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

ТМБҮЧ 2023: 3.4 заалтын үндэслэл

- Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, шинэ Үндсэн хууль батлагдан 1993-1995 онуудад мөнгөн тэмдэгтүүдээ шинэ загвартайгаар хэвлэж, гүйлгээнд гаргасан. Энэ хугацаанд 20,000-тын дэвсгэртэйг 2006 онд хэвлэж гаргаснаас хойш шинэ дүнтэй аливаа дэвсгэрт гаргаагүй. Өнөөдөр Монгол улсын бэлэн мөнгөний гүйлгээнд 1-т, 5-т, 10-т, 20-т, 50-т, 100-т, 500-т, 1000-т, 5000-т, 10000-т, 20000-тын гэсэн нийт 11 төрлийн цаасан тэмдэгт хүчин төгөлдөр ашиглагдаж байна.
- Одоогийн мөнгөн дэвсгэртүүдийг анх гаргаснаас хойшхи 30 орчим жилийн хугацаанд мөнгөн тэмдэгтийн бүтэц, худалдан авах чадварт дараах өөрчлөлтүүд гарчээ:
 - Хамгийн том дүнтэй дэвсгэрт нийт гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний **67 хувийг** дангаараа эзэлж, ачаалал нь хэт ихэссэн. Хоёр дахь том дэвсгэрт 21 **хувийг** эзэлж байна.
 - Мөнгөн тэмдэгтийн тухайлбал 20,000-тын мөнгөн тэмдэгтийн бодит худалдан авах чадварыг инфляциас хамааруулан өнөөгийн байдлаар тооцвол анх гүйлгээнд гаргаж байсан үеэс **70 хувиар буурсан буюу 5960 төгрөгтэй (2006 оны үнээр)** тэнцэж байна.
 - Манай улстай орлогын түвшингээрээ ойролцоо улсуудын хамгийн том мөнгөн дэвсгэрт нь дунджаар **40 ам.доллартой** тэнцэж байхад МУ-ын хамгийн том дэвсгэрт 2022 оны эхний хагас жилийн байдлаар **6.4 ам.доллартай** тэнцэж байна.
 - МУ-тай ойролцоо түвшний хөгжиж буй бусад орнуудтай харьцуулж үзэхэд дундаж **цалинг** том дүнтэй дэвсгэртээр **бэлнээр олгоход 5-6 ширхэг дэвсгэрт** шаардагдаж байхад манай улсад энэ үзүүлэлт **10 дахин өндөр** байна.
- Эдгээр хүчин зүйлсийг харгалзан Монгол улсын мөнгөн тэмдэгтийг эдийн засгийн ач холбогдол бүхий үр ашигтай зохистой бүтэцтэй болгох, үүний тулд шаардлагагүй зарим жижиг дэвсгэртүүдийг гүйлгээнээс хасах, 20,000-таас илүү том нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэрт гаргах арга хэмжээг авах шаардлага үүссэн.





Анхаарал хандуулсанд баярлалаа!

Вебсайт: www.mongolbank.mn



@mongolbank_mn



@mongolbank.mn



mongolbank